

БАТЛАВ:

БОАЖЯ ХБОБНУГ-ЫН ДАРГА:

/ Г.ЭНХМӨНХ /

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“МИЛКО” ХХК-ийн захирал



/ Э.ДАВААХҮҮ /

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
18-Р ХОРООНД БАЙРЛАХ “МИЛКО” ХХК-ИЙН
“СҮҮ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА, ШҮҮС БОЛОН ЧИПСНИЙ
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

БОАЖЯ ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН:

БОЛОВСРУУЛСАН:

“МИЛКО” ХХК-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕР:

Т. Сувдаа

Т.СУВДАА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас
Төсөл хэрэгжүүлэгч, хуулийн этгээдийн товч мэдээлэл

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	“Милко” ХХК
	БОННУ тайлангийн дугаар	2015/КНН015
	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Хүнсний үйлдвэрлэл
	Захиралын нэр, утас, цахим шуудан	Э.Даваахүү, 88099757, davaakhuu@teso.mn
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудан	Т.Сувдаа, 88105955, environmental-manager@teso.mn
1.2	Төслийн нэр	Сүү болон чипсний үйлдвэр
	Төслийн харьяаллын байршил	СХД-н 18-р хороо 131/2-71 тоот
	Төслийн ангилал	Хамааралгүй
	Төсөл эхэлсэн огноо	2003
	Төсөл хэрэгжих хугацаа	-
	Уурхайн хаалт эхлэх огноо	Хамааралгүй
	Хаалтын дараах зориулалт	Хамааралгүй
	ТЭЗҮ батлагдсан огноо	Хамааралгүй
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ	-
	Ажилчдын тоо	450
	Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
	Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Хамааралгүй

Химийн бодисын эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл
3.1	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ	
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдлийн үед авах арга хэмжээ - Учируулах хор хөнөөлийг бууруулах зайлуулах арга хэмжээ - Хохиролыг нөхөн төлөх арга хэмжээ 	
3.2	<ul style="list-style-type: none"> - Шатах тослох материалын нэр төрөл - Тэсрэх, дэлбэрэх бодисын нэр төрөл 	
3.3	Тухайн жилийн хог хаягдлын дундаж хэмжээ <ul style="list-style-type: none"> - Ахуйн хаягдал - Үйлдвэрийн хаягдал - Аюултай хаягдал 	
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн төсөв	1100.0мян.төг

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2023 оны төсөв

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл /мян.төг/
4.1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	10350.0
	Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх арга хэмжээний төсөв	6370.0
	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	
	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв	-
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, ногоон байгууламж төсөв	3500.0

Нөлөөллийн бүс дэхь оршин суугчидад тайлагнах төсөв	0.0
Удирдлага зохион байгуулалтын төсөв	-
Нүүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэх төлөвлөгөөний төсөв	-
Орчны хяналт шинжилгээний нийт төсөв	480.0

Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт

Байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тооцсон эсэх	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тооцсон эсэх	Дүгнэлт
Нөлөөллөөс урьдачлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	7	Тийм	Тийм	
Нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
Нөхөн сэргээлт	-	-	-	
Дүйцүүлэн хамгаалах	-	-	-	
Оршин суугчидад тайлагнах	1	Тийм	Тийм	
Түүх соёлын өвийг хамгаалах	-	-	-	
Удирдлага зохион байгуулалт	1	Тийм	Тийм	

Орчны хяналт шинжилгээний хяналтын хуудас

Хяналт шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв
Хөрс	2	Хашааны гадна хогийн цэгийн орчим, үүдний зогсоол орчим	Жилд 2	120.0мян.төг
Ус	1	Үйлдвэрийн хаягдал усны хоолой	Улиралд 1	60.0мян.төг
Амьтан	-	-	-	-
Ургамал	-	-	-	-
Агаар	3	Агуулахын байранд 2, гадна талбайд 1	Жилд 2	300.0мян.төг

БАЙГАЛЬ ОРЧНЫ 2020 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУГААНГУЙ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга зүй

“Милко“ ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт хэрэгжүүлж буй “Сүү болон чипсний үйлдвэрийн төсөл“-ийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖЯамны 2019 оны 5-р сарын 10-ний өдрийн 13/3076 тоот ерөнхий үнэлгээний дагуу байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Хас Цаг“ ХХК-н боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол, 2019-2023 оны менежментийн төлөвлөгөөг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам“-ын дагуу боловсрууллаа.

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2009 онд ТЭСО корпорациас хэрэгжүүлсэн сүү, сүүн бүтээгдэхүүн, ундаа жүүсний үйлдвэрлэлийн төслөөр байгуулагдсан 2010 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн, 10 жилийн түүхтэй. 2.2га газартай, үүнээс 0.95га нь үйлдвэрийн барилга түүхий эдийн түүхий агуулах зэрэгтэй. Үндсэн 3 үйлдвэртэй

Милко шингэн хүнсний үйлдвэр - 2010 онд байгуулагдсан

Хуурай сүүний үйлдвэр - 2014 онд байгуулагдсан

Кингснейк үйлдвэр - 2005 онд байгуулагдсан /2018 онд нэгдсэн/

Үйлдвэрийн хашаа дотроо төмөр замтай, нэг дор 6 вагон хүлээн авах боломжтой.

“Милко“ ХХК-ний хуурай сүүний үйлдвэрийн төсөл нь импортыг орлох үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлын хүрээнд жилд 4000-7000тн хуурай сүү үйлдвэрлэх хүчин чадалтай. Одоогоор ЗӨВ БРЕНД бүтээгдэхүүнүүд /аарцны ундаа, хатаасан аарц, үрэл/, ГОЛДЕН МИЛК хуурай сүүг тогтмол үйлдвэрлэж БНХАУ, Казакстан улс зэрэг дэлхийн томоохон хөгжингүй орнуудад экспортонд гаргаж, үндэсний шилдэг бүтээгдэхүүн болон үйл ажиллагааныхаа хүрээгээ тэлж цаашид зах зээл нь улам бүр тэлж, өсөн нэмэгдэх хэрэглэгчдийн шаардлагыг тасралтгүй хангах, зах зээлд тохирсон маркетинг, менежментийн бодлогыг хөгжүүлж ажиллаж байна.

Байгаль орчин нийгмийн хүрээнд хэрэгжүүлж буй ажилууд

“Милко“ ХХК Монгол улсын хууль, тогтоомж, Байгаль орчны ерөнхий үнэлгээ, БОННУ-н шаардлагуудыг дагаж мөрдөн БОМТ- гөө хэрэгжүүлэхийн зэрэгцээ харилцагч Азийн хөгжлийн банкны Хамгаалалтын бодлого, журам түүний Байгаль орчин нийгмийн удирдлагад үйл ажиллагаагаа нийцүүлэх, олон улсын стандартад хүрхээр ажиллаж байна. Эрчим хүчний хэрэглээ, Хаягдал ус, Хог хаягдал зэрэг үйлдвэрлэлээс байгаль орчин түүний нөөцөд нөлөөлөж буй нөлөөллүүдийг бууруулах, хамгийн бага хэмжээнд байлгахад анхааран ажиллаж үр дүнд нь Эрчим хүчний менежментийн тогтолцоо ISO 50001:2015 стандартыг амжилттай нэвтрүүлэн, хаягдал ус, хог хаягдлын менежментийг сайжруулан Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 стандартыг 2021 онд амжилттай нэвтрүүлсэн.

ХОЁР. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн нэр

Сүү сүүн бүтээгдэхүүн, ундаа, шүүс болон чипсний үйлдвэр

Төслийн зорилго


“Милко” үйлдвэр нь хүнсний хамгийн эмзэг түүхий эд болох сүүг чанар, шимт байдлыг нь алдагдуулахгүйгээр өндөр түвшинд боловсруулах технологи, тоног төхөөрөмжийг эзэмшиж хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн хүргэх, уламжлалт сүүн бүтээгдэхүүнийг орчин үеийн технологиор баяжуулан үйлдвэрлэх зорилго тавин ажиллаж байна. Энэхүү зорилгоо “Уламжлалыг шинэчилнэ” уриан дор хэрэгжүүлсээр байна.

Төсөл хэрэгжүүлэгч

Хувийн хөрөнгө оруулалттай “Милко” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011209006, Регистрийн дугаар: 5327059, Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 000304984, 000465586, 00031835, 0000318351

Төслийн байршил

“Милко” ХХК-ны “Сүү сүүн бүтээгдэхүүн, ундаа, шүүс болон чипсний үйлдвэр”-ийн төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт 2.2га талбайд байрлаж байна.



Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Төсөл хэрэгжиж буй талбайн гаднах орчны байдал

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс газар, газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

“Милко” ХХК-н “Сүү сүүн бүтээгдэхүүн, ундаа, шүүс болон чипсний үйлдвэр” төслийн талбай Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт 2.2га талбайд байрлаж байна. Уг газрын төлөв байдал нь үндсэндээ байгалийн унаган төрхөө алдсан, хүн, техникийн нөлөөгөөр элэгдэл, эвдрэлд өртсөн байдалтай байдаг. “Милко” ХХК үйлдвэрлэлийн бүс, эзэмшлийн талбайгаа бүхэлд нь хатуу хучилтаар хучсан байдаг. Ерөнхий үнэлгээнд тусгагдсанаар БОННУ нэмэлт тодотголын хүрээнд төслийн байршилтай холбоотой асуудлыг тодруулхад төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар орон нутгийн хэтийн хөгжилд ашиглхаар төлөвлсөн газар байдаггүй.



Зураг 3. Төсөл хэрэгжиж буй талбай бүхэлдээ хатуу хучилттай

Агаарын чанар

Төслөөс түгээлтэнд ашиглагддаг тээврийн хэрэгсэлүүдээс өөрөөр агаарын чанарт нөлөөлөх нөлөөлөл байхгүй эсвэл шууд. Харин улаанбаатар хотын агаарын чанар гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, TSP тоосонцор, Дуу чимээ болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон химийн аргаар тодорхойлход.

2022 оны хүйтний улиралын 09 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг 2021 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулхад TSP тоосонцор 33мкг/м³-ээр буурсан бол Хүхэрлэг хий 4мкг/м³-ээр өссөн, азотын хий 5мкг/м³-ээр өссөн байна, Агаарын чанарынстандартын хүлцэх агууламж давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 1. Агаарын чанарын үзүүлэлт

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт	Дундаж агууламж, мкг/м ³	
		Хүлцэх агууламж мкг/м ³	2021 оны 10-р сар
Дуу чимээ	60	60	54
TSP тоосонцор	0.500	0.080	0.047
Хүхэрлэг хий SO ₂	0.450	0.011	0.015
Азотын давхар исэл NO ₂	0.200	0.017	0.022

Тус төслийн талбай орчим хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөр болон зөвшөөрөх хэмжээнээс хэтрэх нөхцөл үүсээгүй байна.

Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал

Үйлдвэр бүс эргэн тойрондоо байшин барилга, хашаагаар хүрээлэгдсэн Туул голын хөндийд байралдаг. Энэ бүсэд 0.3м хүртэл сайр чулуу гололсон, бор хүрэн өнгийн хөрс шороо чулууны засвараар тогтсон байх ба ширхэгийн бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар зонхилсон, бүтэц муутай хөрс байна. Хөрсний хими шинжилгээний дүнгээс үзэхэд ялзмагийн хэмжээ бага 1.64 хувь, урвалын орчин сул шүлтлэг рН-8.6, ширхэгийн бүрэлдэхүүнд физик шавар 20 хувь хүрч хөрс хөнгөн шавранцар бүрэлдхүүнтэй байна.

Хүснэгт 2. Хөрсний үржил шимийн үзүүлэлт

Гүн	рН	cond	Давс	Ялзмаг	CO ₂	Солилцох суурь			Шим тэжээлийн үзүүлэлт		
						Ca	Mg	нийлбэр	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
см		dsm	%	%	%	мг-экв/100г			мг/100г		
0-5	8.6	0.217	0.10	1.64	1.15	11.9	4.2	16.1	0.06	1.6	8
5-20	8.2	0.078	0.04	1.19	0.82	8.0	3.1	11.1	0.09	1.2	11

Хүснэгт 3. Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % /мм-ээр/							
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
	0-5	29.3	28.0	22.7	10.0	7.1	3.0	20.0	
	5-20	53.8	28.5	6.8	0.4	6.7	3.8	10.9	

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл талбай бүрхэлдээ хатуу хучилттай тул хөрсөн бүрхэвчид шууд нөлөөлөл үгүй.

Хүснэгт 4. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Газрын гадаргуу, хөрсөн бүрхэвчийн тогтоц алдагдаж хөрсний үржил шимт үнэт нөөц багасах	х			
2	Түүхий эд, хатуу хог хаягдлын улмаас хөрс бохирдож болзошгүй	х			
3	Түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн улмаас талбайн гаднах талбайд шатах тослох материал алдагдах, тоосжилт үүсэх	х			
		3			

Хэсгийн дүгнэлт- Нийт нөлөөллийн 100 хувь бага гэсэн үнэлгээтэй байгаа нь хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл Бага зэрэг байгааг харуулж байна

Төслийн усан орчинд нөлөөлөх нөлөөлөл

Төслийн талбай нь ус зүйн сүлжээний хувьд Туул голын сав газарт багтах бөгөөд Туул голын хөндийд голоос 3км гаруй зайд оршино. Төслийн талбай нь төв суурин үйлдвэрийн бүс учир ойр орчимд булаг, шанд, гол горхи, гадаргын усан сүлжээ байхгүй. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй.

- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хаягдал /технологийн хаягдал ус/ хөрсийг бохирдуулсанаас усан орчинд шууд бусаар нөлөөлнө

- Унд ахуйн ус болон технологийн хэрэглээний ус ашиглах учир усны нөөцөд тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

Хүснэгт 5. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Төслийн явцад гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл	-			
2	Төслийн хэрэгцээнд ус ашигласнаар усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл		х		
3	Хог хаягдлын нөлөөгөөр усны чанарт үзүүлэх нөлөөлөл	х			
	Нийт	1	1		

Хэсгийн дүгнэлт- Нийт нөлөөллийн 50 хувь бага 50 хувь дунд гэсэн ангилалд багтаж байгаа тул тус төслөөс тухайн нутгийн усны нөөц, чанарт нөлөөлөх нөлөөллийн зэргийг дунд зэрэг сөрөг гэж дүгнэж байна.

Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал

Үйлдвэрийн байр нь үйлдвэрүүд төвлөрсөн дүүрэгт орших бөгөөд орчин тойрных нь үржил шимт хөрс, ургамалан нөмрөг үндсэндээ үгүй болсон. Төсөл хэрэгжиж буй газар нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Голо-арктикийн их муж, Евроазийн мужийн Төв Монголын хошууны Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт багтана. Төслийн талбай орчимд хялгана хиаг-алаг өвст бүлгэмдэл тархаж байсан. Төслөөс ургамалан нөмрөгт дараах байдлаар нөлөөлөх магадлалтай.

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах

- Үйлдвэрлэлийн бүсэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан тэр орчмын газар талхлагдалд өртөж ургамалан нөмрөг устгах

- Барилга байгууламж барих зэрэг ахуйн болон бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл хувьсаж өөрчлөгднө.

Хүснэгт 6. Ургамалан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эрчим

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Барилга байгууламжийн улмаас ургамалан нөмрөгт нөлөөлсөн байдал		х		
2	Талбай доторх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	х			
3	Хатуу шингэн хог хаягдал	х			
	Нийт	2	1		

Хэсгийн дүгнэлт- Нийт нөлөөллийн 66.7 хувь бага 33.3 хувь дунд гэсэн ангилалд багтаж байгаа тул тус төслөөс ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага зэрэг байгааг харуулж байна.

Төслөөс нийгэм эдийн засаг, хүн амд нөлөөлөх нөлөөлөл

Ажиллагсдын эрүүл ахуйд хортой хүчин зүйлүүд нөлөөлөхөөс хамгаалах, нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах техник хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал хувцас хэрэгслээр хангах ариун цэврийн системийг журамчлан бүрэн тогтоож өгч чадсан байгааг нарийвчилсан үнэлгээнд тусгасан.

Агуулахын байрны гэрэлтүүлэг, температур, чийглэг, орчны тоосжилт, агаар дахь химийн бодисын агууламж зэрэг бичил орчны үзүүлэлтүүд стандарт нормын хэмжээнээс өөр байх нөхцөлд ажилчдын эрүүл мэндэд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх эсхийг тогтмол орчны шинжилгээ болон эрүүл мэндийн шинжилгээтэй харьцуулж хяналтандаа байлгадаг.

БОННУ-НИЙ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

“Сүү сүүн бүтээгдэхүүн, ундаа, шүүс болон чипсний үйлдвэр”-ийн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнгүүдийг нэгтгэх нь байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчин болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсүүд, түүн дэхь нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэсэн. Энэхүү нэгтгэл нь БОННУ-ний тайлангийн үр дүнд үндэслэн эцсийн шийдвэрийг гаргах нөхцөлийг бүрдүүлдэг.

Тус төслөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үр дүнгүүдийг нэгтгэн доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 7. Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Аюултай
Байгаль орчин				
Газрын гадарга, хэвлий	-3	0	0	0
Гадаргын ба гүний ус	-1	-1	0	0
Агаарын чанар	-2	-1	0	0
Хөрс	-3	0	0	0
Ургамал	-2	-1	0	0
Амьтан	-3	-1	0	0
Нийт нөлөөллийн тоо	14	4	0	0
Эзлэх хувь	77.8	22.2	0	0
Нийгэм эдийн засгийн орчин				
Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	0	+3	0	0
Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	-2	-1	0	0
Түүх соёлын дурсгал	0	0	0	0
Нийт нөлөөллийн тоо	2	4	0	0
Эзлэх хувь	20	80	0	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 77.8 хувь нь бага, 22.2 хувь дунд зэрэг байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 50 хувь дунд /эерэг/, 16.7 хувь дунд зэрэг /сөрөг/, 33.3 хувь нь бага зэрэг сөрөг нөлөөтэй байна. Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл БАГА зэрэг сөрөг нөлөөтэй байна.			

Тайлбар: - Сөрөг нөлөөтэй
+ Эерэг нөлөөтэй

Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөний гол зорилт

“Милко“ ХХК Хуулиар хүлээсэн үүрэг Байгаль орчны ерөнхий үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан шаардлага үйлдвэрлэл, үйлчилгээгээ олон улсын стандартын шаардлагад нийцүүлхээр компанийн байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахаар ажиллаж байна. Үүний нэг хэсэг болсон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 онд хамаарах ажлыг түүвэрлэн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын дагуу боловсрууллаа.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /Мян.төг/	Нийт зардал /Мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаар орчин						
Хөргүүрт ашиглах хөргөлтийн бодис	Орчны болон ажлын байрын агаарын бохирдолын байдалд жилд 1 удаа шинжилгээ хийх	Үйлдвэр, агуулахын хүрээнд	-	-	2023	Гамшгаас хамгаалах тухай хууль 27.1
Гэнэтийн осол, гамшгаас урьдчилан сэргийлэх	Үйлдвэрийн байрны галын дохиоллыг иж бүрэн шинэчилнэ, системтэй болгох	Үйлдвэр, агуулахын хүрээнд	-	15000.0	2023	
2. Дуу чимээ						
Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлэх	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Агуулах, төв байранд	-	-		MNS ISO 226:2003 Дуу чимээ хэвийн норм түвшиний чимээ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангах	Ажиллагсад	20.0	60 x 20.0 1200.0	2023 онд	
	Дуу шуугианд хэмжилт хийх	Агуулах, төвийн байр	30.0	30x3 270.0	Жилд 3 удаа	
3. Усны нөөц, чанар						
Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэргэлснээр усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Усны нөөц хомсодхоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд			Тогтмол	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Усны тухай хууль

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<p>Болзошгүй осол, саатал, техник технологийн болон шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх</p> <p>Байгалийн гамшиг, түүнээс урьдчлан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p>	Техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	ҮА зардалд	ҮА зардалд	Өдөр бүр тогтмол /инженерүүд/	Гамшгаас хамгаалах тухай хууль 27.1
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд бүх ажилчдад	500.0	ҮА зардалд	Сургалтыг улирал бүрт 1 удаа	
	Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт зохион байгуулах		200.0	ҮА зардалд	2023 онд	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	ХХА зардал	-	2023 онд	
	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр /хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил маск/ хангах	Шйл ажиллагааны турш				
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэрэгжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	ҮА зардалд		2023 онд	

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Жил бүр	350.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлаг зайлуулж буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Төслийн эхэн үед болон ашиглалтын үед	250.0	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Буцаалтаар устгаж байгаа бүтээгдэхүүнийг саармагжуулж шугам хаях мөн ариутгал цэвэрлэгээний бодисын үлдэгдэлд хяналт тавих	Төслийн хүрээнд	500.0	
Хийн хаягдал гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр бүрийн ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах		-	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээлэлийн агуулга	Зохион байгуулах хугацааний тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
СХД-н 18-р хорооны иргэд	Уулзалт	БОМТ, хяналт шинжилгээ	10-11-р сар	-	Байгаль орчны бодлогын менежер	Хорооны иргэдийн уулзалтын байранд эсвэл компанийн хуралын өрөө
Нийслэлийн байгаль орчны газар-т	Хэвэлмэл тайлан	БОМТ хэрэгжилт	11.01-ний дотор	-	Байгаль орчин бодлогын менежер	-
БОАЖЯ	www.eic.mn	БОМТ	Тухай оны 01 сар	-	Байгаль орчин бодлогын менежер	-

2023 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал /мян.төг/	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар /Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх/	Үйлдвэр, агуулахын байранд 2 цэг, химийн бодисын гадна хашаанд 1 цэг	Агаарын найрлага улиралд 1 удаа	25.0x4 удаа x 3 цэг Нийт 300.0	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384-1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048-1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:2008 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS ISO 226:2003 Дуу чимээ-Хэвийн норм MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Усны хяналт шинжилгээ	Хаягдал усны хоолойноос	Хагас жилд 1	30.0 x 2удаа Нийт 60.0	MNS ISO 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 13.060.50 Усны чанарын стандарт
Хөрсний төлөв байдал. Бохирдол	Агуулах, үйлдвэрийн хашааны гадна Хатуу хог хаягдлын талбайн ойр тус бүр нэг цэг	Жилд 2 удаа	2 цэг x 2 дээж x 2 удаа x 20.0=80.0 Хүнд металл 2 цэг x 1 дээж x 2 удаа x 20.0=40.0	MNS 3307:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалага, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлийн болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
2023 оны нийт зардал			480.0	

ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Хэрэгжих байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал /мян.төг/
Үйлдвэрийн орчны тохижилт, ажилчдын амрах саравч	Оффисын гадна талбай	жилд нэг удаа	500,000
Цэцэрлэгжүүлэлт, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Ногоон байгууламж дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ /арчилгаа тордолгоо/	Жил бүр	3,000,000
2023 оны нийт зардал			3,500,000



2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө